



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын
Зөвлөлийн мэдээлэл, Радио, Зурагт радиогийн
Улсын Хороо, Бүгд Найрамдах Ардчилсан Герман
Улсын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Зурагт
радиогийн Улсын Хорооны хооронд зурагт радио
гийн талаар хамтран ажиллах 1971 оны ажлын

п р о т о к о л

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан
Герман Улсын хооронд 1968 оны 9-р сарын 12-нд байгуулагдсан
найрамдал, хамтын ажиллагааны гэрээ, түүний гуравдугаар зүй-
лийн дагуу Монголын зурагт радио, БНАГУ-ын зурагт радио доор-
хи зүйлээр хэлэлцэн тохиролцов.

Нэгдүгээр зүйл

Монголын зурагт радио, Монгол Ардын Хувьсгалын 50 жилийн
ойд зориулсан монголын ард түмний ололт амжилтыг харуу-
сан зурагт радиогийн програмыг 1971 оны тавдугаар сарын 1-
ний дотор БНАГУ-ын зурагт радиод явуулна.

Хоёрдугаар зүйл

Монголын зурагт радио Монгол Ардын Хувьсгалын 50 жилийн
ойд зориулсан зурагт радиогийн кино авахуулахаар БНАГУ-ын
зурагт радиогийн кино группын 3 хүнийг нэг сарын хугацаагаар
хүлээн авна. /Хавсралтын нэгдүгээр зүйл/

Гуравдугаар зүйл

Монголын зурагт радио, БНАГУ-ын зурагт радио нь өөрсдийн
орни улс төр, эдийн засаг, соёлын хөгжлийг харуулсан зурагт
радиогийн мэдээг сард 3-аас доошгүй удаа солилцож байна.

Дөрөвдүгээр зүйл

1. Монголын зурагт радио, БНАГУ-ын зурагт радио зурагт радиогийн нэдээлэл, нийтлэл, уран сайхны болон драм, хөгжим, хүүхэд залуучуудын сэдэв бүхий зурагт радиогийн нэвтрүүлгийг тогмол сонилцох байна.

2. Хоёр талын зурагт радиогийн станцууд нь дээрхи зүйлийг үзэх, шилэж авах бололцоог бие биедээ олгоно.

Тавдугаар зүйл

БНАГУ-ын зурагт радио хүүхэд залуучуудад зориулсан утга зохиол, эрдэм дэлгэрүүлэх сэдэв бүхий соронзон хальсан дээр бичсэн нэвтрүүлгийг Монголын зурагт радиод явуулна.

Зургаадугаар зүйл

Монголын зурагт радио, БНАГУ-ын зурагт радио эдийн засаг, шинжлэх ухаан ба соёлын тухай зурагт радиогийн нэвтрүүлгийн талибаруудыг сонилцохдоо бэлэн байгаагаа мэдэгдэх байна.

Хоёрдугаар зүйл

БНАГУ-ын зурагт радио Монголын зурагт радиогийн нэг ажилтанг /оператор/ хадгалах хийгэхээр нэг сарын хугацаагаар хэргээн авна. /Хавсралтын хоёрдугаар зүйл/

Найдугаар зүйл

Элсн үлсэн, зурагт радиогийн ба бөгөөд хөгжмийн баримт киноны дэвсгэрийн 14-р дэвсгэрийн Монголын зурагт радио төлөөлөгчөө киноны хамт оруулна. /Хавсралтын гуравдугаар зүйл/

- 3 -

Бсдүгээр зүйл

Монголын зурагт радио, БНАГУ-ын зурагт радио нь Олон
Улсын Радио, Зурагт радиогийн Байгууллагтай нягт хамтран
ажиллана.

Аравдугаар зүйл

Монголын зурагт радио, БНАГУ-ын зурагт радиогийн бүрэн
эрх бүхий төлөөлөгчид 1971 оны эцсээр Улаабаатарт буруу
Берлинд уулзаж, хоёр байгууллагын хоорондын хамтын ажиллагаа-
ны удаан хугацааны хэлэлцээр байгуулах ба дуоогийн байгуулсан
ажлын протоколын биемэлтийг дүгнэж, 1972 оны ажлын протоколд
гарын үсэг зурах ажлыг гүйцэтгэнэ.


Энэхүү протоколыг 1976 оны II-р сарын 24-нд Берлин
хотноос Монгол, герман хэл дээр хоёр хувь үйлдсэн бөгөөд
эх тус бүр нь адил хүчинтэй.

БНАГУ-ын Сайд нарын Зөвлөл-
ийн Мэдээлэл, Радио, Зурагт
радиогийн Улсын Хорооны өм-
нөөс Монголын зурагт радио-
гийн ерөнхий захирал

БНАГУ-ын Сайд нарын Зөвлөлийн
дээрэгдэх Зурагт радиогийн
Улсын Хорооны өмнөөс Зурагт
радиогийн ерөнхий захирал



Г. СУМИЯЛА



ХАЙНЦ АДАМЕК



Хавсралт

Нэгдүгээрт – Германы зурагт радиогийн кино группыг явуулах тухай.

Хугацаа: 1971 оны 5 дугаар сарын 1-ээс
6дугаар сарын 1-ний дотор

Редактор Лёвенберг, оператор, туслах оператор
Монголын зурагт радио, кино группын байх хуга-
цааны хоол, байр, унаа, хэлмэрчийн зардлыг
даана.

Хоёрдугаарт- Дадлага хийх хүний тухай

Хугацаа: 1971 оны 9 дүгээр сард хүлээн авна.
Монголын зурагт радиогийн ажилтны дадлагын
ажилтай холбогдсон бүх зардлыг БНАГУ-ын зурагт
радио даана. / өдрийн зардал 25 марк, зочид
буудал, хэлмэрч / орос хэлний /

Гуравдугаарт-Фестивалийн хугацаа,

1971 оны II дүгээр сарын 20-оос 27-нд